



**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН  
ТОГТООЛ**

2023 оны 12 сарын 06 өдөр

Дугаар 432

Улаанбаатар хот

**Журам батлах тухай**

Боловсролын ерөнхий хуулийн 24.1.13-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

1.“Боловсролын цахим мэдээллийн сангийн бүртгэл, мэдээлэл солилцох, хадгалах, хамгаалах, баяжуулах, ашиглах журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2.Энэ журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгаланд даалгасугай.



**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД**

**Л.ОЮУН-ЭРДЭНЭ**

**БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ  
УХААНЫ САЙД**

**Л.ЭНХ-АМГАЛАН**

Засгийн газрын 2023 оны 12 дугаар  
сарын 06 -ны өдрийн 432 дугаар  
ТОГТООЛЫН ХАВСРАЛТ

**БОЛОВСРОЛЫН ЦАХИМ МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН БҮРТГЭЛ,  
МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОХ, ХАДГАЛАХ, ХАМГААЛАХ,  
БАЯЖУУЛАХ, АШИГЛАХ ЖУРАМ**

**Нэг.Нийтлэг үндэслэл**

1.1.Боловсролын ерөнхий хуулийн 43.3-т заасан Боловсролын цахим мэдээллийн сан (цаашид "мэдээллийн сан" гэх)-г бүрдүүлэх, мэдээллийг бүртгэх, баяжуулах, ашиглах, мэдээлэл солилцох, хадгалах, хамгаалахтай холбогдсон үйл ажиллагааг энэ журмаар зохицуулна.

1.2.Мэдээллийн санг бүрдүүлэх, ашиглах, хадгалах, хамгаалах, мэдээлэл солилцох чиг үүрэгтэй эрх бүхий албан тушаалтан, хуулийн этгээд болон хууль тогтоомжид заасан холбогдох бусад байгууллага энэ журмыг мөрдөнө.

**Хоёр.Боловсролын цахим мэдээллийн сан**

2.1.Мэдээллийн сан нь Боловсролын ерөнхий хуулийн 43.3-т заасан мэдээллээс бүрдэх бөгөөд баяжуулах, ашиглахтай боловсролын салбарын мэдээлэл, чанарын үнэлгээний болон боловсрол сургалтын байгууллагад сургалтын зориулалтаар ашиглагдаж байгаа систем, программ хангамжаар дамжуулан бүрдүүлнэ.

2.2.Мэдээллийн санд мэдээлэл бүртгэх, баяжуулах, баталгаажуулах чиг үүргийг хариуцсан албан хаагч мэдээллийн үнэн, бодит байдлыг хариуцаж ажиллана.

2.3.Мэдээллийн сан нь Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 4.1.8-д заасан мэдээлэл хариуцагчтай байна.

2.4.Мэдээллийн сан, түүний боловсруулалтын үр дүн, холбогдох мэдээ тайлан нь мэдээлэл хариуцагчийн албан ёсны мэдээ, мэдээлэл, баримт бичиг байна.

2.5.Мэдээллийн санд боловсролын салбарын мэдээллийг төвлөрүүлэн байршуулах бөгөөд мэдээллийг баталгаажуулахдаа блокчейн болон бусад дэвшилтэд технологийг ашиглаж болно.

2.6.Мэдээллийн сангийн мэдээлэл бодит бус байгаа нь баримтаар нотлогдвол залруулгыг хийхдээ Боловсролын ерөнхий хуулийн 43.7-д заасан журмыг баримтална.

2.7.Мэдээллийн сан, түүний нөөц хувилбарыг Архивын тухай хууль болон бусад холбогдох хууль, журамд заасан хугацаанд хадгална.

2.8.Мэдээллийн сан нь боловсролын өгөгдлийн тайлбар толь бичигтэй байж болно.

2.9.Мэдээлэл хариуцагч нь мэдээллийн санг салбарын бодлого, төлөвлөлт, батлагдсан маягт, үзүүлэлт, аргачлалын дагуу тогтоосон хугацаанд шинэчлэн бүрдүүлнэ.

2.10.Мэдээлэл хариуцагч нь Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 27.10-д заасан нэгдсэн ангилал, код, тайлбарыг мөрдөнө. Мэдээллийн сангийн ангилал, код, тайлбарыг давхардуулахгүй.

### Гурав.Бүртгэх, мэдээлэл солилцох

3.1.“Боловсролын салбарын мэдээлэл солилцооны систем” (цаашид “мэдээлэл солилцооны систем”) гэж боловсролын салбарт ашиглагдаж байгаа мэдээллийн систем, программ хангамж, тэдгээрийн мэдээллийн сан хооронд харилцан мэдээлэл солилцох зориулалттай төрийн мэдээлэл солилцооны үндсэн (ХУР) системийн бүрэлдэхүүн хэсэг байна.

3.2.Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь мэдээлэл солилцооны систем, сервисийн жагсаалт болон сервис хөгжүүлэлтийн төлөвлөлтийг батлах бөгөөд энэ журмын 3.6-д заасан систем хөгжүүлэгчээс мэдээлэл солилцох тухай хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлэнэ.

3.3.Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь сервис хөгжүүлэлт, холболт, туршилт, түүний хандалтын бодит цаг хугацаанд хяналт тавьж ажиллана.

3.4.Боловсролын мэдээллийн технологийн төв (цаашид “БМТТ” гэх) нь мэдээлэл солилцооны систем болон сервис хөгжүүлэлтийг хариуцаж ажиллах бөгөөд мэдээлэл солилцооны системийн сервис үйлчилгээний заавар, аргачлалыг боловсруулж, нэгдсэн хэлбэрээр цахим хуудсанд байршуулна.

3.5.Мэдээлэл солилцооны системийг боловсролын салбарын хэмжээнд ашиглах бөгөөд бусад салбар хооронд мэдээлэл солилцохдоо Боловсролын ерөнхий хуулийн 24.1.8-д заасан “Боловсролын цахим мэдээллийн сангийн систем, техник технологи, программ хангамжийн ерөнхий шаардлага болон төрийн цахим мэдээллийн сан хариуцсан байгууллагатай мэдээлэл солилцох журам”-ыг баримтална.

3.6.Программ хангамж хөгжүүлэгч хувь хүн, хуулийн этгээд болон бусад (цаашид “систем хөгжүүлэгч” гэх) мэдээллийн системд тавих ерөнхий шаардлага хангасан систем хөгжүүлэгч нь Боловсролын ерөнхий хуулийн 43.7-д заасан журмын дагуу мэдээлэл солилцох тухай албан хүсэлтийг сервис үйлчилгээний нэр, зориулалт, холбоо барих мэдээллийн хамт боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ.

3.7.Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага систем хөгжүүлэгчтэй энэ журмын 5.2-т заасан нууцын баталгаа гаргасны үндсэн дээр мэдээлэл солилцох гэрээ байгуулж, уг гэрээний хуулбарыг боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болон БМТТ-д хүргүүлнэ.

3.8. Систем хөгжүүлэгч нь өөрийн хөгжүүлсэн бүтээгдэхүүн (систем, программ хангамж)-д Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 4.1.9, 4.1.10-д заасны дагуу холбогдох дүгнэлт авсан байх бөгөөд системийн үйлчилгээ үзүүлж байгаа боловсролын сургалтын байгууллагатай холбогдох хууль, журмын дагуу гэрээ байгуулсан байна.

3.9. Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага энэ журмын 3.8-д заасан гэрээний дагуу мэдээлэл солилцох бүртгэл хийж, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж, дүнг улирал тутамд боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад мэдээлнэ.

3.10. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага боловсролын салбарын үйл ажиллагааг цахимжуулахтай холбоотой үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилгоор мэдээлэл солилцох гэрээг систем хөгжүүлэгчтэй байгуулж, эрх олгосон зөвшөөрлийг БМТТ-д олгоно.

3.11. Мэдээллийн сервист мэдээлэл хариуцагчийн нийлүүлж байгаа мэдээлэлд өөрчлөлт оруулах тохиолдолд БМТТ-д урьдчилан мэдэгдэнэ.

3.12. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ журмын 3.6-д заасан албан хүсэлтийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 10 хоногт багтаан шийдвэрлэнэ.

3.13. БМТТ нь мэдээлэл солилцох гэрээг хүлээн авснаас хойш хөгжүүлэлтийн ажлыг ажлын 20 хоногт багтаан хийж, ашиглалтад оруулах бөгөөд тухайн сервисийн цар хүрээ, техникийн нөхцөл байдлаас хамаарч нэг удаа ажлын 10 хоногоор сунгаж болно.

3.14. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гэрээний бүртгэлийн санг хөтөлж, хадгалалт, хамгаалалтыг хариуцна.

#### Дөрөв. Хадгалах, хамгаалах

4.1. Мэдээллийн санг "Үндэсний дата төв"-д байрлах "Боловсролын дата төв" дээр байршуулж хадгалах бөгөөд газар зүйн өөр байршилд нөөц (backup) болон толин сервер (mirror)-ийн дэд бүтэцтэй байна.

4.2. Мэдээллийн сангийн нууцлал, хадгалалт, хамгаалалтын найдвартай байдлыг Боловсролын ерөнхий хуулийн 43.4-т заасны дагуу БМТТ хариуцаж ажиллана.

4.3. Энэ журмын 2.3-т заасан мэдээлэл хариуцагч нь мэдээллийн сангийн нууцлал, аюулгүй байдлыг хангах чиглэлээр дараах арга хэмжээг авна:

4.3.1. болзошгүй аюул болон эмзэг байдал, эрсдэлийг тодорхойлж, түүний магадлалыг тооцоолох;

4.3.2. аюулгүй байдлыг хангах ажиглалтыг тасралтгүй хийж, халдлага, зөрчлийн бүртгэлийг хөтөлж, нэгтгэх;

4.3.3. нууцлал, аюулгүй байдал алдагдсан гэж үзвэл шуурхай хариу арга хэмжээ авах, нөхөн сэргээх;

4.3.4.нууц үгийн нууцлал, аюулгүй байдлын бодлогыг хэрэгжүүлэх;

4.3.5.нууцлал, аюулгүй байдлын чиглэлээр холбогдох сургалтыг зохион байгуулж, шаардлага тавих;

4.3.6.мэдээллийн системийн хөгжүүлэлтийг зориулалтын орчинд хийх бөгөөд туршилтад ашиглах бодит бус мэдээллийн сантай байх;

4.3.7.мэдээллийн систем, түүний сервер, сүлжээнд мөрдөгдөж буй дүрэм, журам, зааврыг виртуал серверүүд дээр нэгэн адил мөрдөх;

4.3.8.SSL шифрлэлт болон ашиглагдаж буй программ хангамжуудыг албан ёсны лицензтэй хэрэглэх;

4.3.9.нэвтрэх эрх хаагдсан, түдгэлзүүлсэн хэрэглэгчийн систем ашиглаж байсан үеийн түүхийг устгахгүй гэж хууль, журамд заасан хугацаагаар хадгалах;

4.3.10.мэдээллийн санд мэдээллийн аюулгүй байдлын эрсдэл үүссэн, сэжигтэй хандалт илэрсэн, гэрээнд зааснаас өөр зорилгоор мэдээллийг ашигласан зэрэг болон эрх бүхий байгууллагаас шаардсан тохиолдолд тухайн системийг бүхэлд нь, эсвэл хэсэгчлэн зогсоох;

4.3.11.кибер аюулгүй байдлын журам болон холбогдох стандартыг чанд мөрдөж, зөвлөмж, шаардлагыг биелүүлэх.

4.4.Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага мэдээллийн сангийн үйл ажиллагаа, мэдээллийн чанар, бодит байдал, тохирцод төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, түүний мөрөөр шаардлагатай арга хэмжээг авна.

4.5.Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага мэдээллийн санд кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ, мэдээллийн аюулгүй байдлын аудитыг Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасны дагуу хийлгэж, түүний мөрөөр шаардлагатай арга хэмжээ авна.

4.6.Мэдээллийн систем хөгжүүлэгчийн мэдээлэл бүртгэх, мэдээлэл солилцох, баяжуулсан мэдээллийн системийн үйлдлийн бүртгэлийг БМТТ бүртгэж, хяналт тавина.

4.7.БМТТ нь мэдээллийн санд өөрчлөлт, засвар оруулахгүй бөгөөд мэдээллийг бусдад дамжуулахгүй болон нийтэд мэдээлэхгүй байх үүрэг хүлээнэ.

#### Тав.Ашиглах

5.1.Мэдээлэл хариуцагч нь мэдээллийн санд агуулагдаж байгаа нээлттэй өгөгдлийг машинд уншигдах бүтэцтэй хэлбэрээр, өөрийн цахим хуудсанд болон төрийн нээлттэй өгөгдлийн порталд ил тод байршуулна.

5.2 Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасны дагуу мэдээллийг ашиглах эрх бүхий иргэн, хуулийн этгээд нь Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 22.1-д заасан шаардлагыг хангасан, нууц задруулахгүй байх баталгааг бичгээр гаргасан байна.



5.3.Мэдээлэл ашиглах эрх бүхий иргэн, хуулийн этгээд энэ журмын 5.2-т заасныг хэрэгжүүлэхдээ боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрөл авсан байна.

5.4.Цаасан хэлбэрээр мэдээлэл, лавлагаа, тодорхойлолт өгөхтэй холбогдон гарах төлбөрийг “Журам батлах тухай” Засгийн газрын 2022 оны 206 дугаар тогтоол, Засгийн газраас баталсан нээлттэй өгөгдлийн жагсаалтад ороогүй, эсхүл нээлттэй өгөгдлийг нийтлэхээс өмнө иргэн, хуулийн этгээдийн хүсэлтээр нээлттэй өгөгдөл боловсруулж өгөхтэй холбогдон гарах төлбөрийг “Аргачлал батлах тухай” Засгийн газрын 2022 оны 202 дугаар тогтоолоор баталсан аргачлалын дагуу тус тус тооцно.

### Зургаа.Хяналт, хариуцлага

6.1.Мэдээлэл хариуцагч нь мэдээллийн сангаас бусад эх үүсвэрээс авсан, боловсруулсан аливаа мэдээ, мэдээлэлд хариуцлага хүлээхгүй.

6.2.Мэдээллийн сангийн хэвийн үйл ажиллагаа алдагдсанаас үүсэх аливаа эрсдэлд БМТТ болон систем хөгжүүлэгч байгууллага холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хариуцлага хүлээнэ.

6.3.Мэдээллийн сан хариуцах болон ашиглах чиг үүрэг бүхий ажилтан нь албан үүргийн дагуу олж авсан мэдээллийг хувийн зорилгоор ашиглахгүй байх болон гуравдагч этгээдэд дамжуулахгүй байх үүрэг хүлээнэ.

6.4.Мэдээлэл солилцох гэрээ байгуулсан систем хөгжүүлэгч байгууллага мэдээллийн санд мэдээлэл нийлүүлэлт, мэдээллийн алдагдалд оруулсан тохиолдолд сануулах арга хэмжээ авч, үүссэн хохирлыг барагдуулах бөгөөд давтан зөрчил гаргавал мэдээлэл солилцох гэрээг цуцлах арга хэмжээ авна.

6.5.Мэдээллийн сангийн мэдээллийн бүртгэл, нэгтгэл, баяжуулалт, хадгалалт, хамгаалалтын үйл ажиллагаанд хяналт тавих үе шат, мэдээллийн сангийн мэдээллийн зөрчилтэй байдалд хяналт, хариуцлага тооцох үйл ажиллагааг Боловсролын ерөнхий хуулийн 43.7-д заасан журмын дагуу зохицуулна.

6.6.Мэдээлэл солилцох гэрээ байгуулсан систем хөгжүүлэгч байгууллага болон мэдээлэл хариуцагч байгууллагын гэрээнд хяналт шалгалт хийх, үр дүнг тайлагнах үйл ажиллагаанд Боловсролын ерөнхий хуулийн 43.7-д заасан журмыг дагаж мөрдөнө.